



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/713.

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл балансаас  
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5.1, 5.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн “Төр захиргааны авто бааз” УТҮГ-ын хөрөнгөд бүртгэлтэй 226,000,000.00 (хоёр зуун хорин зургаан сая) төгрөгийн бүртгэлийн үнэ, 116,766,666.85 (нэг зуун арван зургаан сая долоон зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг наян таван мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй, 01-64 УНИ улсын дугаартай, Тоёота Ланд крузер-200 маркийн тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн “Төр захиргааны авто бааз” УТҮГ (Э.Болор-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

2.Тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу бүртгэн авч, өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Нийслэлийн “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ (Ч.Элбэгсайхан)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110203349